



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А/367

Хэрлэн сум

Төрийн бус өмчийн сургуулийн өмнөх  
боловсролын байгууллагад хүүхэд элсүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7<sup>1</sup>.2, 15 дугаар зүйлийн 15.1, Их хурлын 2016 оны "Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 47 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэцэрлэгийн хүрэлцээ хангалтгүй байгаатай холбогдуулан Хэрлэн сумын зарим багийн хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах зорилгоор Боловсрол, соёл, урлагийн газрын саналыг үндэслэн төрийн бус өмчийн "Бамбар", "Жүржхэн" цэцэрлэгүүдэд 40 хүүхдийг элсүүлэх ажлыг зохион байгуулсугай.

2. Дээрх цэцэрлэгүүдэд нэг хүүхдэд ногдох хувьсах болон хоолны зардлыг зохих журмын дагуу тооцож олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, хуваарилсан хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролын сургалтад бүрэн хамруулахыг цэцэрлэгийн эрхлэгч нарт, сургалтын явц, үр дүнг улирал бүр тайлагнахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/-т, цэцэрлэгүүдийн сургалтын орчны эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА